



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗАР**

14190 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо,
Их тойруу, Утас: 32 05 02, Факс: (976-11) 32 02 74,
И-мэйл: contact@burtgel.gov.mn, Вэбсайт: www.burtgel.gov.mn

2019.11.29 № 1/9411

танай _____-ны № _____-т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Ц.НЯМДОРЖ ТАНАА**

Сангийн сайдын 2018 оны 281 тоот тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу тус газрын 2019 оны худалдан авах ажиллагааны жилийн тайланг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт: 31 хуудастай.

ДАРГА



Б.БААСАНДОРЖ



Боловсруулсан: *З. Дорж Чехан*
Мягсаан: *С. Тогтоол*
Хувь: *2:1*
Огноо: *2019.11.29*

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны
11/28/11 тоот албан бичгийн 1 дүгээр хавсралт

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2019 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Тус газрын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтын эх үүсвэр тус бүрээр тоо баримт, биелэлтийн хувь болон зохион байгуулсан худалдан авалтын талаар:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалт, урсгал төсвөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж баталсан. Төлөвлөгөө болон гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Тендер шалгаруулалтын нэр, код	Төсөвт өртөг /сая төг/	Багцын нэр	Гэрээ байгуулсан байгууллага нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний үнийн дүн /сая төгрөг/	Гэрээний үүргийн хэрэгжилт
1	Улсын мэдээллийн маягт	475.0	Гэрчилгээ, маягт-багц1	Үндэсний үнэт цаас ХХК	2019.08.14	69.4	100 хувь
2			Дэвтэр, мэдүүлэг, маягт-багц2	Адмон принт ХХК	2019.06.14	140.5	100 хувь
3			Хавтас-багц3	Соёмбо принт ХХК	2019.08.14	44.4	100 хувь
4			Үнэмлэх, гэрчилгээ-багц4	2019.11.25-ны өдөр нээсэн	Нээлтэд Үндэсний үнэт цаас ХХК оролцохоор материалаа ирүүлсэн, үнийн санал 127.1 сая төгрөг, үнэлгээний хороо ажиллаж байна.		
5	Бичиг хэрэг-	130.0	Бичгийн цаас- Багц1	Төгс дардас ХХК	2019.08.14	43.0	100 хувь
6			Принтерийн хор- Багц2	Футурвижн ХХК	2019.08.14	47.8	100 хувь

7	Тавилга	36.0	Тавилга-Багц1	Хашхан ХХК	2019.06.21	10.0	100 хувь
8			Сейф- Багц2	Лүндээ-Очир ХХК	2019.05.15	15.6	100 хувь
9	Багаж, техник хэрэгсэл	100.0	нэг багцат	Саммит компьютер технологи ХХК	2019.10.18	98.9	нийлүүлэх хугацаа болоогүй
10	Шатахуун	25.2	нэг багцат	Петростар ХХК	2019.03.05	24.5	100 хувь
11	Гадаад паспортын бэлдэц	3,600.0	нэг багцат	G&D Co.Ltd	2019.03.25	3,615.0	100 хувь
12	Иргэний үнэмлэхийн бэлдэц	3,223.7	нэг багцат	Смарткарт ХХК	2019.03.25	3,223.7	100 хувь
13	Улсын бүртгэгчийн тэмдэг	39.2	нэг багцат	Хак трейд ХХК			Гэрээ байгуулагүй
	ДҮН	7,629.1				7,332.8	92.3 хувь

Улсын төсвийн урсгал төсвөөр санхүүжүүлэх шууд гэрээ 1 буюу нууц 2, нээлттэй тендер шалгаруулалт 8, харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт 2, нийт 13 худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь 2019 оны байдлаар худалдан авах ажиллагаатай холбоотой дараах ажил хийгдсэн. Үүнд:

Нэг.Шууд гэрээ

ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан Хууль сахиулах салбарын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын 9 дэх заалт болон Хууль зүй дотоод хэргийн сайдын баталсан ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу дараах бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан болно. Үүнд:

1.1 Смарт карт ХХК-тай 2019 оны Н-19/02, СК-19/002 тоот шууд гэрээ байгуулж, нийлүүлсэн иргэний үнэмлэхийн бэлдэцийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/189 тоот тушаалаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-ийн гишүүд акт үйлдэж, дараах байдлаар хүлээн авсан болно.

- 2019 оны 3 сарын 7-ны өдөр -18 000 ширхэг, 4 сарын 3-ны өдөр 32 000 ширхэг, 5 сарын 27-ны өдөр 52 000 ширхэг, 6 сарын 3-ны өдөр 48 000 ширхэг, 8 сарын 7-ны өдөр 100 000 ширхэг, нийт 250 000 ширхэгийг гэрээнд заасан техникийн тодорхойлолт, шалгуур

үзүүлэлтийн дагуу тоолж, шалган хүлээн авсан бөгөөд нийт төлбөрт 3 223,7 сая төгрөгийг төлсөн.

1.2. ХБНГУ-ын "VERIDOS" компанитай Үүнд: 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 2918-0018-09 тоот гэрээний дагуу нийлүүлэх 250 000 ширхэг, 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр 100 000 ширхэг, нийт 350 000 ширхэг үндэсний энгийн гадаад паспортын бэлдэцийг гэрээнд тусгасан хуваарийн дагуу урьдчилгаа төлбөр төлсний дараа Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/163 тоот тушаалаар байгуулагдсан "Ажлын хэсэг"-ийн гишүүд акт үйлдэж, дараах байдлаар хүлээн авсан болно.

- 2019 оны 2 сарын 8-ны өдөр 15 000 ширхэг, 3 сарын 18-ны өдөр 85 000 ширхэг, 6 сарын 18-ны өдөр 150 000 ширхэг, 9 сарын 30-ны өдөр 101 000 ширхэг, нийт 351 000 ширхэгийг гэрээнд заасан техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийн дагуу тоолж, шалган хүлээн авсан бөгөөд нийт төлбөрт 3 616,0 сая төгрөгийг шилжүүлээд байна.

Хоёр. Нээлттэй тендер шалгаруулалт

ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дах заалт болон Хууль зүй дотоод хэргийн сайдын баталсан ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалын дагуу дараах ажлууд хийгдсэн. Үүнд:

2.1 Улсын мэдээллийн маягт нийлүүлэх тендер

2.1.1 УБЕГ/201901001 дугаар бүхий 3 багцат тендерийг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр өдрийн сонин, www.tender.gov.mn, www.burtgel.gov.mn сайтад тендерийн урилгыг байршуулж, нээлтийг хийхэд дараах байгууллагууд оролцохоор тендерийн материалыг ирүүлсэн.

1 дүгээр багц №2019010011- Гэрчилгээ, маягт

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн баталгаа
1	Адмон принт ХХК	52 602 000	791 600
2	Соёмбо принтинг ХХК	72 202 000	791 600
3	Монголын үнэт цаас, хэвлэл ХХК	72 149 000	791 600
4	Үндэсний үнэт цаас ХХК	42 240 000	791 600

2 дугаар багц №2019010012 –Дэвтэр, мэдүүлэг, маягт

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн баталгаа
1	Адмон принт ХХК	140 500 800	526 170
2	Соёмбо принтинг ХХК	116 060 000	526 170
3	Монголын үнэт цаас,	150 773 000	526 170

	хэвлэл ХХК		
--	------------	--	--

3 дугаар багц №2019010013 –Хавтас

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн баталгаа
1	Нэг-Үүд ХХК	63 200 000	499 200
2	Соёмбо принтинг ХХК	44 400 000	499 200
3	Монголын үнэт цаас, хэвлэл ХХК	82 567 000	499 200

Тендер шалгаруулалтын тухай

- **Гэрчилгээ, маягт буюу 1 дүгээр багцад** орсон компаниуд шалгаруулалтын хүснэгтийн 34-т заасан “Тендерийн баримт бичгийн талаарх нууцлалыг нууцын баталгаа авсны дараа нээлт хийхээс ажлын 5 хоногоос багагүй хугацааны дотор танилцана” гэж заасны дагуу нууцлалтай ирж танилцсан тендерт оролцогч байхгүй байсан тул уг багцыг хүчингүй болгосон.
- **Дэвтэр, мэдүүлэг, маягт буюу 2 дугаар багцад** Соёмбопринтинг ХХК-ийн ирүүлсэн материалыг үзэх явцад шалгаруулалтын хүснэгтийн үнэт цаас маягтыг нийлүүлсний дараа чанарын шаардлага хангаагүй тоо хэмжээгээр дахин нийлүүлнэ гэж заасныг биелүүлээгүй, ирүүлсэн загвар нь шаардлага хангаагүй шалтгаанаар хянан үзэх шатнаас хасагдсан. Адмонпринт ХХК, Монголын үнэт цаас, хэвлэл ХХК-ийн материалуудыг хянан үзэхэд бүх шаардлагыг бүрэн хангаж үнэлэх шатанд тэнцэж, бага үнийн саналаар Адмонпринт ХХК нь шалгарсан.
- **Хавтас буюу 3 дугаар багцад** Соёмбопринтинг ХХК-ийн ирүүлсэн материал дутуу шалтгаанаар хянан үзэх боломжгүй, “Нэг-Үүд” ХХК, Монголын үнэт цаас, хэвлэл ХХК – ийн материал шаардлагад нийцэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дэх хэсэгт зааснаар захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5 хувиар хэтэрсэн тул шаардлагад нийцээгүй тул уг багцыг хүчингүй болгосон байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/160 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны хурал 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж дараах дүгнэлтийг гаргасан.

- 1 дүгээр багц, 3 дугаар багцын шаардлагад нийцэх тендер ирээгүй байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.1 дэх хэсэгт заасны дагуу дахин нээлттэй тендер шалгаруулалт явуулах;
- 2 дугаар багцын тендерт “Адмонпринт” ХХК ирүүлсэн тендер Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх хэсэгт заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарч, гэрээ байгуулах эрх олгох саналыг захиалагчид танилцуулах шийдвэр гаргаж захиалагчид танилцуулсан.

ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасныг баримтлан тус тендерийн нийт багцад 2019 оны 4 сарын 15-ны өдөр бүх оролцогч байгууллагуудад нэгэн зэрэг албан тоотоор, 2 дугаар багцад шалгарсан Адмонпринт ХХК-д 3/2043 тоотоор гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдсэн. Гэвч оролцогч Соёмбопринтинг ХХК нь Сангийн

яаманд гомдол гаргаж Сангийн яамын 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6-1/2647 тоот албан бичгээр тендерийг дахин үнэлэх шийдвэр ирүүлсний дагуу тус тендерийн 2 дугаар багцыг дахин үнэлж 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хуралдаж дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргасан.

2019010012 дугаартай багцад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан, 28 дугаар зүйлийн 28.3, 28.7.4-т заасны дагуу хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр "Адмонпринт" ХХК-ийн ирүүлсэн тендерийг 140 500 800 төгрөгөөр дэвтэр, мэдүүлэг, маягтыг нийлүүлэхээр шалгарч, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2019 оны 5 сарын 24-ны өдөр 3/4097 тоотгоор хүргүүлсэн.

2.1.2 Улсын мэдээллийн маягт нийлүүлэх 1,3 дугаар багцын тендерийг дахин зарлахаар тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж, захиалагчаар батлуулж, 1 дүгээр багц №2019010011- Гэрчилгээ, маягт, 3 дугаар багц №2019010013 –Хавтасын тендерийг 2019 оны 6 сарын 10-ны өдөр зарлаад 2019 оны 7 сарын 10-ны өдөр нээсэн.

1 дүгээр багц №2019010011- Гэрчилгээ, маягт

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн баталгаа
1	Соёмбо принтинг ХХК	50 872 000	791 600
2	Үндэсний үнэт цаас ХХК	69 432 000	791 600

3 дугаар багц №2019010013 –Хавтас

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн баталгаа
1	Соёмбо принтинг ХХК	44 400 000	499 200

Тендер шалгаруулалтын тухай

- **Гэрчилгээ, маягт буюу 1 дүгээр багцад** Соёмбо принтинг ХХК-ийн ирүүлсэн тендер нь техникийн тодорхойлолт хангаагүй тул хуулийн 27 дугаар зүйлийн 27,4 дэх заалтыг үндэслэн уг тендерээс татгалзсан. Харин Үндэсний үнэт цаас ХХК нь бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тул үнэлгээ хийх шатанд үлдэж шалгарсан.
- **Дэвтэр, мэдүүлэг, маягт буюу 2 дугаар багцад** Соёмбопринтинг ХХК-нь ирүүлсэн тендер захиалагчаас тогтоосон бүх шаардлагыг хангаж байгаа тул уг байгууллага нь шалгарсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/160 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооны хурал 2019 оны 7 дугаар сарын 23-ний өдөр хуралдаж дараах дүгнэлтийг гаргасан.

- 1 дүгээр багцад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх хэсэгт заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул Үндэсний үнэт цаас ХХК-тай гэрээ байгуулах;
- 2 дугаар багцад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4 дэх хэсэгт заасны дагуу “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул “Соёмбо принтинг” ХХК –тай гэрээ байгуулах эрх олгох саналыг захиалагчид танилцуулах шийдвэр гаргаж захиалагчид танилцуулсан.

Үнэлгээний хорооны дүгнэлтийг захилагч хүлээн зөвшөөрч 2019 оны 7 сарын 26-ны өдрийн 3/5667 тоотой гэрчилгээ, маягтын багцад 69 432 000 төгрөгөөр нийлүүлэхээр шалгарсан Үндэсний үнэт цаас ХХК, 2019 оны 7 сарын 26-ны өдрийн 3/5669 тоотой хавтас багцад 44 400 000 төгрөгөөр нийлүүлэхээр шалгарсан Соёмбо принтинг ХХК-тай гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн.

Гэрээний үүргийн хэрэгжилт/1,2,3 дугаар багцын хувьд/-100 хувь:

Үндэсний үнэт цаас ХХК нь бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу гэрээнд заасан 7 төрлийн 654 200 ширхэг гэрчилгээ, иргэний улсын бүртгэлийн болон лавлагааны маягтыг, Соёмбопринтинг ХХК нь бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу гэрээнд заасан 6 төрлийн 36 000 ширхэг хавтас, дугтуйг бүрэн нийлүүлж ажилласан.

2.1.3 Улсын мэдээллийн маягт нийлүүлэх 4 дүгээр багц буюу “Үнэмлэх, гэрчилгээ” тендерийн баримт бичгийг захиалагчаар батлуулж, тендерийг 2019 оны 10 сарын 25-ны өдөр зарлаад 2019 оны 11 сарын 25-ны өдөр нээсэн.

Уг тендерт Үндэсний үнэт цаас ХХК-нь оролцохоор тендерийн материалыг ирүүлж шалгаруулахаар ажиллаж байна.

2.2. Бичиг хэрэг нийлүүлэх тендер

УБЕГ/201901002 дугаар бүхий 2 багцат тендерийг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр өдрийн сонин, www.tender.gov.mn, www.burtgel.gov.mn сайтад тендерийн урилгыг байршуулж, нээлтийг хийхэд дараах байгууллагууд оролцохоор тендерийн материалыг ирүүлсэн.

1 дүгээр багц №2019010021- Бичгийн цаас

- Төгс дардас ХХК, Макс экзим ХХК, Содпресс ХХК-3 байгууллага;

2 дугаар багц №2019010022-Принтерийн хор

- Вега экспресс ХХК, Секьюрити солюшн сервис консалтинг ХХК, Номт марал ХХК, Ай Си Би Си ХХК, Төгс дардас ХХК, Тенер инк сервис консалтинг ХХК, Футурвижн ХХК, Фэйд трий ХХК гэсэн 8 байгууллага оролцохоор тендерийн материалыг ирүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/65 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2019 оны 4 сарын 19-ний өдөр хуралдаж УБЕГ/201901002 тоот 2 багцад тендерт оролцогчид шаардлага хангасан нэг ч оролцогч байгаагүй тул дахин тендер зарлахаар дүгнэлтийг захиалагчид 2019 оны 4 сарын 22-ний өдөр хүргүүлсэн.

ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасныг баримтлан уг тендерийн нийт багцын үр дүнг 2019 оны 4 сарын 26-ны өдөр бүх оролцогч байгууллагуудад нэгэн зэрэг албан тоотоор мэдэгдсэн.

УБЕГ/201901002-1 тендерийг дахин зарлахаар тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж, захиалагчаар батлуулж, 2019 оны 5 сарын 9-ны өдөр зарлаж, нээлтийг 2019 оны 6 сарын 10-ны өдөр нээсэн, тендерт оролцогчдоос төлөөлөл болж "Интер ном" ХХК-ийн менежер Г.Гэрэлцэцэг оролцсон.

Бичгийн цаас нийлүүлэх /Багц-1/ тендерт саналаа ирүүлсэн оролцогчийн үнийн саналыг хүснэгтээр үзүүлэв.

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн баталгаа
1	Интер ном ХХК	42 960 000	432 000
2	Төгс дардас ХХК	42 960 000	432 000
3	Сод пресс ХХК	42 240 000	432 000

Принтерийн хор нийлүүлэх /Багц-2/ тендерт саналаа ирүүлсэн оролцогчийн үнийн саналыг хүснэгтээр үзүүлэв:

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Тендерийн баталгаа
1	Төнер инк сервис ХХК	55 597 000	773 900
2	Ай Си Би Си ХХК	48 640 000	773 900
3	Дижитал сервис ХХК	44 616 000	773 900
4	Вега экспресс ХХК	49 552 000	773 900
5	Төгс дардас ХХК	52 074 000	773 900
6	Номт марал ХХК	42 595 000	773 900
7	Футурвижн ХХК	47 767 500	773 900

Тендер шалгаруулалтын тухай

- **Бичгийн цаас буюу 1 дүгээр багцад** Содпресс ХХК нь Харилцагч банкнаас зээл олгох боломжтой тухай тодорхойлолт болон дансны хуулга ирүүлээгүй, 2017, 2018 оны туршлагын мэдээлэл ирүүлээгүй. Сүүлийн 2 жилийн гэрээний мэдээлэл, харилцагч байгууллагын тодорхойлолт, бараа хүлээлцсэн акт ирүүлээгүй. Интер ном ХХК нь ирүүлсэн материалыг хянан үзэхэд маягт ТШМ 5В буюу одоо хэрэгжиж буй гэрээний мэдээллийг ирүүлээгүй гэсэн шалтгаанаар хянан үзэх шатанд хасагдсан. Төгс дардас ХХК нь захиалагчийн шаардлагад нийцэж, үнэлэх шатанд шалгарсан.

- **Принтерийн хор буюу 2 дугаар багцад** Тенер инк сервис ХХК нь ТШӨХ-ийн 4.2.5 ба 4.2.8-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг ирүүлээгүй, Ай Би Си ХХК-нь ТООЗ-ын 1.4, 12.1(е), 19.1-д заасан шаардлагыг хангаагүй буюу нийлүүлэх барааны нэр, төрөл, тоо ширхэгийг өөрчлөн бараа нийлүүлэлтийн болон үнийн хуваарийг ирүүлсэн, харилцагч 3 байгууллагын тодорхойлолт ирүүлээгүй. Дижитал сервис ХХК нь ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага /Маягт ТШМ-5Б/ ирүүлээгүй, 2017 оны гэрээ байхгүй, ажил хүлээлцсэн акт дутуу, Вега экспрес ХХК_ТООЗ-ын 1.4, 12.1(е), 19.1-д заасан шаардлагыг хангаагүй буюу нийлүүлэх барааны нэр, төрлийг өөрчлөн бараа нийлүүлэлийн болон үнийн хуваарийг ирүүлсэн, ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага /Маягт ТШМ-5Б/, одоо хэрэгжиж буй гэрээний мэдээлэл /Маягт ТШМ-5В ирүүлээгүй, Төгс дардас ХХК нь 2018 онд хэрэгжүүлсэн гэрээний мэдээлэл ирүүлээгүй, Номт марал ХХК нь 2018 онд хэрэгжүүлсэн гэрээний мэдээлэл ирүүлээгүй зэрэг шалтгаанаар хянан үзэх шатнаас хасагдсан. Футурвижн ХХК-нь хянан үзэхэд бүрэн хангаж, үнэлэх шатанд шалгарсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/65 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2019 оны 6 сарын 20-ний өдөр хуралдаж дараах шийдвэр гарсан.

- Бичгийн цаас буюу 1 дүгээр багцад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3, 28.7.4 дэх хэсэгт зааснаар Төгс дардас ХХК-д 42 960 000 төгрөгөөр бичгийн цаас нийлүүлэхээр;
- Принтерийн хор буюу 2 дугаар багцад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3, 28.7.4 дэх хэсэгт зааснаар Футурвижн ХХК-д 47 767 500 төгрөгөөр принтерийн хор нийлүүлэхээр шалгарч, гэрээ байгуулах эрх олгох саналыг захиалагчид танилцуулах шийдвэр гаргаж, танилцуулсан.

ТБОНӨХБАУХАТухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасныг баримтлан уг тендерийн нийт багцын үр дүнг 2019 оны 7 сарын 04-ны өдөр бүх оролцогч байгууллагуудад нэгэн зэрэг албан тоотоор, Футурвижн ХХК-д принтерийн хор нийлүүлэх гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2019 оны 7 дугаар сарын 04-ны өдөр 1/5248, Төгс дардас ХХК-д бичгийн цаас нийлүүлэхээр гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2019 оны 7 дугаар сарын 04-ны өдрийн 1/5241 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Ерөнхий газрын даргын шийдвэрээр Төгс дардас ХХК-тай бичгийн цаас нийлүүлэх гэрээг 2019 оны 8 дугаар сарын 4-ны өдрийн А/875 тоот тушаал, Футурвижн ХХК -тай тавилга, эд хогшил нийлүүлэх гэрээг 2019 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн А/878 тоот тушаалаар Тамгын газар даргад зөвшөөрсөн.

Гэрээний хэрэгжилт-100 хувь:

Төгс дардас ХХК нь нийлүүлэх бичгийн цаасыг хуваарийн дагуу бүрэн нийлүүлж байгаа бөгөөд Футурвижн ХХК нь мөн л хуваарийн дагуу принтерийн хорыг бүрэн нийлүүлж байна.

2.3. Тавилга нийлүүлэх тендер

УБЕГ/201901003 дугаар бүхий 2 багцат тендерийг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр өдрийн сонин, www.tender.gov.mn, www.burtgel.gov.mn сайтад тендерийн урилгыг байршуулж, нээлтийг хийхэд дараах байгууллагууд оролцохоор тендерийн материалыг ирүүлсэн.

1 дүгээр багц №2019010031- Тавилга

- Хашхан ХХК, Брунел ган ХХК -2 байгууллага;

2 дугаар багц №2019010032 – Сейф

- Хашхан ХХК, Брунел ган ХХК, Лүндээ-Очир ХХК гэсэн 3 байгууллага оролцохоор тендерийн материалаа ирүүлсэн.

Тендер шалгаруулалтын тухай

- **Тавилга буюу 1 дүгээр багцад** Брунел ган ХХК нь татварын өртэй, бусад шаардсан материал дутуу шалтгаанаар хасагдсан. Хашхан ХХК-ийн ирүүлсэн материалыг хянан үзэхэд захиалагчийн шаардлагад нийцэж, үнэлэх шатанд шалгарсан.
- **Сейф буюу 2 дугаар багцад** Брунел ган ХХК нь татварын өртэй, бусад шаардсан материал дутуу шалтгаанаар, Хашхан ХХК-ийн ирүүлсэн материалыг хянан үзэхэд бүх шаардлагыг бүрэн хангаж үнэлэх шатанд өндөр үнэтэй хасагдсан. Лүндээ-Очир ХХК-ийн ирүүлсэн материалыг хянан үзэхэд бүрэн хангаж, хамгийн бага үнийн саналаар шалгарсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/69 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо 2019 оны 4 сарын 20-ний өдөр хуралдаж дараах шийдвэр гарсан.

- Тавилга буюу 1 дүгээр багцад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3, 28.7.4 дэх хэсэгт зааснаар Хашхан ХХК нь 9 974 000 төгрөгөөр тавилга нийлүүлэхээр;
- Сейф буюу 2 дугаар багцын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.3, 28.7.4 дэх хэсэгт зааснаар Лүндээ-Очир ХХК нь 15 600 000 төгрөгөөр архивын нягтруулсан шүүгээ нийлүүлэхээр шалгарч, гэрээ байгуулах эрх олгох саналыг захиалагчид танилцуулах шийдвэр гаргаж, танилцуулсан.

ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасныг баримтлан уг тендерийн нийт багцын үр дүнг 2019 оны 4 сарын 29-ны өдөр бүх оролцогч байгууллагуудад нэгэн зэрэг албан тоотоор, Хашхан ХХК нд 2019 оны 5 сарын 1-ны өдрийн 3/3409 тоотоор, Лүндээ-Очир ХХК нд 2019 оны 5 сарын 1-ны өдрийн 3/3411 албан тоотоор тус тус гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдэл хүргүүлсэн.

Ерөнхий газрын даргын шийдвэрээр Лүндээ-Очир ХХК-тай сейф, шүүгээ нийлүүлэх гэрээг 2019 оны 5 дугаар сарын 24-ны өдрийн А/509 тоот тушаал, Хашхан ХХК-тай тавилга, эд хогшил нийлүүлэх гэрээг 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/619 тоот тушаалаар Тамгын газар даргад зөвшөөрсөн.

Гэрээний хэрэгжилт-100 хувь:

Гэрээний дагуу тавилга, эд хогшил, архивын нягтруулсан шүүгээ, бичгийн сейфыг нийлүүлж хүлээлцсэн акт үйлдсэн.

2.4 Тамга, тэмдэг хийлгэх тендер

Тус газрын даргын 2019 оны А/680 дугаар тушаалаар байгуулагдсан “Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгчийн тэмдэгийг батлагдсан загварын дагуу хийж гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах, үнэлэх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг” 2019 оны 6 сарын -ны өдөр болон 2019 оны 10 сарын 15-ны өдөр тус тус хуралдаж

Гурав.Харьцуулалтын арга

Төлөвлөгөөний дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын шатахуун нийлүүлэх цахим тендерийг 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдөр нээхэд Шунхлай трейдинг ХХК, Петростар ХХК, Магнайтрейд ХХК, Содмонгол групп ХХК гэсэн байгууллагууд оролцохоор тендерийн материалыг ирүүлсэн.

Д/д	Тендерт оролцогчийн нэр	Тендерийн үнийн санал (төгрөг)	Үнийн хөнгөлөлт
1	Магнайтрейд ХХК	25 266 805	758 004
2	Содмонгол групп ХХК	25 266 805	758 004
3	Шунхлай трейдинг ХХК	25 266 805	ирүүлээгүй
4	Петростар ХХК	25 66 805	758 004

Тендер шалгаруулалтын тухай

- Магнайтрейд ХХК, Содмонгол групп ХХК-аас ирүүлсэн тендер нийлүүлэлтийн хугацаанд лабораториор шинжлүүлж, стандарт хангаж байгааг тодорхойлоход татгалзах зүйлгүй талаарх мэдэгдлийг ирүүлээгүй шалтгаанаар шаардлагад нийцээгүй гэж хасагдсан;
- Үнэлгээнд шатанд Шунхлай трейдинг ХХК-ийн тендер өндөр үнэтэй тул тендерээс татгалзаж, хамгийн бага харьцуулах үнэтэй Петростар ХХК-ийн 25 266 805 төгрөг, 758 004 төгрөгийн үнийн хөнгөлөлтийн хасч 24 508 801 төгрөгөөр шалгаруулсан.

Үнэлгээний хорооны шийдвэрээр Петростар ХХК-ийн ирүүлсэн тендер мөн хуулийн 28.3, 28.7.3-т заасны дагуу хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгарч, гэрээ байгуулах эрх олгох саналыг захиалагчид танилцуулахаар тус тус шийдвэрлэж 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдөр 1/1863 тоот албан тоотоор гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж, 2019 оны 3 сарын 15-ны өдөр гэрээ байгуулсан.

Гэрээний хэрэгжилт-100 хувь:

Гэрээнд зааснаар сар бүр нийлүүлэх шатахууны төлбөрийг хуваарийн дагуу төлж шатахуун талоныг авч ажиллаж байна.

1.2. Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авах ажиллагааны талаарх тайлбар, үндэслэл болон хэрэгжилтийн талаар:

Тус байгууллага нь төлөвлөгөөнд тусгаагүй худалдан авалт хийгээгүй.

2.5 Багаж техник хэрэгсэл нийлүүлэх тендер

Тус газрын даргын 2019 оны А/330 дугаар тушаалаар байгуулагдсан “Багаж, техник хэрэгслийн тодорхойлолт бэлтгэх, баримт бичиг боловсруулах, үнийн санал авах, үнэлэх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг” 2019 оны 10 сарын 3-ны өдөр болон 2019 оны 10 сарын 15-ны өдөр тус тус хуралдаж Тагнуулын ерөнхий газрын 2019 оны 9 сарын 18-ны өдрийн 01/1279 тоот зөвлөмжид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг баримтлан ажиллах нь зүйтэй гэсний дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хэрэгцээнд шаардлагатай багаж, техник хэрэгсэл худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд гурван аж ахуйн нэгжээс үнийн санал авсан.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д заасны дагуу үнийн санал авсан компаниуд шаардлага хангасан эсэх нөхцөлийг магадласны үндсэн дээр, ирүүлсэн үнийн саналыг харьцуулалтын аргаар үнэлэн “Саммиткомпьютер технологи” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр тогтож захиалагчид танилцуулж ажилласан.

Бүх санал ирүүлсэн Смарткарт ХХК, Ай Ти Зон ХХК, Саммиткомпьютер технологи ХХК-иудад нэгэн зэрэг албан тоотоор мэдэгдэж, Саммиткомпьютер технологи ХХК-тай 2019 оны 11 сарын 04-ны өдрийн 1/8515 албан тоотоор гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдэл хүргүүлсэн.

1.3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэгдээгүй болон дутуу биелсэн ажлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны талаар:

1.3.1 Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний Улсын бүртгэлийн тухай хууль болон Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулиуд өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дагаж мөрдөх журам, зааврууд шиэнчлэгдэж үүнийг дагаад ашиглаж байгаа иргэдэд олгодог гэрчилгээ, маягтын загвар өөрчлөгдөхөөр байсан.

Иймээс улсын мэдээллийн маягт хэвлэх зардлаас зарцуулдаг уг багцын Үнэмлэх, маягт-багц4/ худалдан авалтыг хойшлуулсан боловч өөрчлөлт удааширсантай холбоотойгоор гэрчилгээ, маягтын нөөц дуусч одоогийн ашиглаж байгаа гэрчилгээний загвараар цөөн тоогоор хэвлүүлэхээр худалдан авалтыг зохион байгуулж байна.

1.3.2 2019 оны үнэт цаас, маягтын нөөцийг дахин тооцсоны үндсэн дээр хангалттай нөөцтэй байгаа болон зарим нэг маягтуудыг цөөн тоогоор хэвлэх тул уг зардлаас хэмнэлт гаргаж байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах ашиглалтын болон бусад зайлшгүй зардалд мөнгийг шилжүүлэн зарцуулж байна.

1.3.3 Ерөнхий газрын даргын зөвлөлийн хурлаар Хяналтын Улсын байцаагч, Улсын бүртгэгчийн нарын ашиглаж байгаа тамга, тэмдгийн загварыг өөрчилсөнтэй холбоотойгоор 2019 онд “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд тэмдэг хэрэглэх журам” шинэчлэн батлагдсан.

Тиймээс худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж шалгаруулсан боловч санхүүжилт дээрээ гацаж удааширсан.

1.4. Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийсэн талаар:

2019 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу бүх л тендер шалгаруулалтын үнэлгээг хуулийн хүрээнд тендер хүчинтэй байх хугацаанд зохион байгуулсан.

1.5. Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчил, түүнийг хэрхэн засаж залруулсан талаар:

2019 оны байдлаар тус газраас зарлагдсан худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан зөрчил байхгүй.

1.6. Худалдан авах ажиллагааны талаар гарсан гомдол, түүнийг шийдвэрлэсэн талаар:

1.6.1. Улсын төсвийн урсгал зардлаас зарласан “Дэвтэр, мэдүүлэг, маягт худалдан авах УБЕГ/201901001 дугаар төсөл арга хэмжээний 2019010012 дугаар бүхий багцад Соёмбо принтинг ХХК-нь Сангийн яаманд гомдол гаргасан.

ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасныг баримтлан тус тендерийн нийт багцад 2019 оны 4 сарын 15-ны өдөр бүх оролцогч байгууллагуудад нэгэн зэрэг албан тоотоор, 2 дугаар багцад шалгарсан Адмонпринт ХХК-д 3/2043 тоотоор гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдсэн. Гэвч оролцогч Соёмбо принтинг ХХК нь Сангийн яаманд гомдол гаргаж Сангийн яамын 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 6-1/2647 тоот албан бичгээр тендерийг дахин үнэлэх шийдвэр ирүүлсний дагуу уг тендерийн 2 дугаар багцыг дахин үнэлж 2019 оны 5 сарын 15-ны өдөр хуралдаж дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргасан.

Сангийн яамнаас ирүүлсэн “Гомдол хянан үзсэн тухай” 6-1/2647 тоот албан бичигт уг цагцад дахин үнэлгээг хийх, бусад тендерийн ажиллагааг түр түдгэлзүүлсэн байна. Үнэлгээний хороо дахин үнэлгээг хийж багц-2 т Адмонпринт ХХК шалгарч, гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл хүргүүлсэн.

Харин тус газраас зарлагдсан бусад худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан санал, гомдол байхгүй.

1.7. Чанар стандартын шаардлага хангасан дотоодын бараа худалдан авсан мөнгөн дүн, нийлүүлэгчийн нэр, гэрээний хэрэгжилтийн талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10¹ дүгээр заалт “Дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах”, Засгийн газрын 2015 оны “Дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалт” батлах тухай 336 дугаар тогтоолыг үндэслэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжин дараах худалдан авалтыг хийсэн. Үүнд:

1.7.1 Адмонпринт ХХК –тай “Дэвтэр, мэдүүлэг, маягт нийлүүлэх тендер”-ийн 140,5 сая төгрөгийн гэрээ байгуулж ажилласан. Гэрээний хэрэгжилт 100 хувь;

1.7.2 Титан би ХХК-тай “Гадаад паспортын захиалгын хуудас” нийлүүлэх 18,0 сая төгрөгийн УБЕГ/201901009 дугаар бүхий гэрээний дагуу захиалгын хуудас хүлээн авсан. Гэрээний хэрэгжилт 100 хувь;

1.7.3 Архивын ерөнхий газартай “Албан бичгийн хэвлэмэл хуудас” нийлүүлэх УБЕГ/201901008 дугаар бүхий гэрээний дагуу 5,3 сая төгрөгийн хэвлэмэл хуудас хүлээн авсан. Гэрээний хэрэгжилт 100 хувь;

1.7.4 Тендерт шалгарч тавилга үйлдвэрлэдэг Хашхан ХХК-тай тавилга нийлүүлэх 10,0 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

1.7.5 Шатахуун нийлүүлэх тендерт шалгарсан Петростар ХХК-тай нийлүүлэх 24,5 сая төгрөгийн гэрээний дагуу шатахуун талоныг сар бүр хуваарийн дагуу хүлээж авч байна. Гэрээний хэрэгжилт 95 хувь.

1.7.6 Бичиг хэргийн тендерт принтерийн хорыг дотооддоо үйлдвэрлэдэг Футурвижн ХХК-наас 47,8 сая төгрөгрөөр принтерийн хор худалдан авсан. Гэрээний хэрэгжилт 95 хувь;

1.7.7 Гэрчилгээ, маягт нийлүүлэх тендерт шалгарсан Үндэсний үнэт цаас ХХК-тай 62,4 сая төгрөгийн гэрээ байгуулж, улсын бүртгэлийн гэрчилгээ, маягтыг хүлээн авч, хэрэгжилт 100 хувь байна.

1.7.8 Хавтас /бүртгэлийн/ нийлүүлэх тендерт шалгарсан Соёмбо принтинг ХХК-тай 44,4 сая төгрөгийн гэрээ байгуулж нийлүүлэх хавтсыг бүрэн хүлээн авсан. Гэрээний хэрэгжилт-100 хувь

Д/д	Бараа, ажил, үйлчилгээ	Нийлүүлэгчийн нэр	Гэрээний дүн
	<u>НИЙТ ДҮН</u>		<u>358 962,6</u>
1	Дэвтэр, мэдүүлэг, маягт	Адмонпринт ХХК	140,500.8
2	Гадаад паспортын захиалгын хуудас	Титан би ХХК	17 100,0
3	Албан бичгийн хэвлэмэл хуудас	Архивын ерөнхий газар	5 279,5
4	Ширээ, сандал	Хашхан ХХК	9,974.0
5	Шатахуун талон	Петростар ХХК	24 508,8
6	Принтерийн хор	Футурвижн ХХК	47 767,5
7	Гэрчилгээ, маягт	Үндэсний үнэт цаас ХХК	69 436,0
8	Хавтас /бүртгэлийн /	Соёмбо принтинг ХХК	44 400,0

ХОЁР. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНД ЦАХИМ СИСТЕМ АШИГЛАСАН ТАЛААР

2.1. Худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан тендер шалгаруулалтын тоо, хувь болон системийн талаар:

Худалдан авах ажиллагааны цахим системээр урсгал зардлаас нээлттэй тендер шалгаруулалт 4, харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт 1 тус тус зарласан, үр дүнг тайлагнасан болно.

Цахим системээр зарласан Тендер шалгаруулалтын тоо, хувийн харуулбал:

Д/д	Бараа, ажил, үйлчилгээ	Тендерийн үнэ	Батлагдсан төсөв	Нийт төсөвт эзлэх хувь
	<u>НИЙТ ДҮН</u>	<u>1,054,194.0</u>	<u>1,446,999.0</u>	<u>65,84</u>
1	Бичиг хэрэгсэл	130,000.0	190,700.0	68.17
2	Тавилга	36,000.0	60,000.0	60.00
3	Багаж техник хэрэгсэл	100,000.0	190,000.0	52,63
4	Тээвэр шатахуун	25,194.0	25,194.0	100.00
5	Улсын мэдээллийн маягт хэвлэх	475,000.0	981,105.0	48,41

2.2. Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн ашиглалт болон тухайн жилд худалдан авсан бараа, үйлчилгээний тоо, мөнгөн дүн, гэрээний хэрэгжилтийн талаар:

Ерөнхий гэрээ байгуулах журмын дагуу цахим дэлгүүрийн худалдан авалт хийгээгүй болно.

2.3. Мэргэжлийн байгууллага ерөнхий гэрээний зохион байгуулсан тендер, шалгарсан аж ахуй нэгжийн тоо, шалгараагүй оролцогчийн үндэслэл болон холбогдох мэдээлэл, худалдан авалт хийсэн бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хэрэгжилтийн талаар:

Худалдан авалт байхгүй.

ГУРАВ. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Дөрөв. Нийслэл, орон нутагт хийгдсэн худалдан авалтын талаар:

	Бараа, үйлчилгээний нэр	Төсөвт өртөг /мянган төгрөг/	Данс бүртгэлд тусгах үнэ /мянган төгрөг/	Нийлүүлэгч байгууллага	Захирамж, эх үүсвэрийн нэр
	НИЙТ ДҮН	275,473.6	274,573.6		
Орон нутгийн сангийн хөрөнгө					
-	<u>Дүн</u>				-

		<u>246,013.3</u>	<u>245,113.3</u>		
1	Суудлын автомашин	15,000.0	14,100.0	Тома алтай ХХК	Ховд аймгийн ЗД-ын 2019 оны А/90 тоот захирамжаар шийдвэрлэсэн.
